

КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2024 оны 03 сарын 22 өдөр

№24/05

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Гүйцэтгэх захирал чөлөөлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Кripto Үндэстэн ХК-ийн Гүйцэтгэх захирал Давааням овогтой Чадраабалыг 2024 оны 3 сарын 21-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Д.Чадраабалын үүрэгт ажлыг 2024 оны 3 сарын 21-ний өдрөөр тасалбар болгон зохих журмын дагуу О.Мөнх-Оргилд хүлээлгэн өгөхийг даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, холбогдох санхүү бүртгэлийн тооцоо хийхийг Нягтлан бодогч (Б.Тэлмүүн)-д даалгасугай.
4. Гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг Хуулийн этгээд Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, өргөдөл хүсэлт гаргах, холбогдох баримт бичигт гарын үсэг зурах, төлөөлөх зэрэг бүрэн эрхийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Уранцэцэг)-д даалгасугай.



Ч.ГАНХУЯГ

КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2024 оны 03 сарын 22 өдөр

№24/06

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Гүйцэтгэх захирал томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, 83 дугаар зүйлийн 83.6, 83.7 дахь хэсэг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Крипто Үндэстэн ХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд Отгонбаяр овогтой Мөнх-Оргил (РД:УК95102210)-ийг 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн томилсугай.
2. Гүйцэтгэх захирал томилогдсонтой холбоотойгоор хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга (Ч.Ганхуяг)-д даалгасугай.
3. Гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг Хуулийн этгээд Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, өргөдөл хүсэлт гаргах, холбогдох баримт бичигт гарын үсэг зурах, төлөөлөх зэрэг бүрэн эрхийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Уранцэцэг)-д даалгасугай.



ДАРГА

Ч.ГАНХУЯГ

КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2024 оны 03 сарын 22 өдөр

№24/04

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ГУЗ-ийн нарийн бичгийн дарга томилох тухай

Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Кripto Үндэстэн ХК-ийн ГУЗ-ийн нарийн бичгийн даргын албан тушаалд Баясгалан овогтой Уранцэцэг (РД:УД89051401)-ийг 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөс томилсугай.
2. ГУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилогдсонтой холбоотойгоор ажилтны хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулахыг Гүйцэтгэх захирал (О.Мөнх-Оргил)-д даалгасугай.

ДАРГА  Ч.ГАНХУЯГ



The stamp is a red circular seal with the text 'УЛААНБААТАР ХОТ' at the top, 'КРИПТО ҮНДЭСТЭН ХК' in the center, and 'К1А223 2105853 907203115' at the bottom.

КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2024 оны 03 сарын 22 өдөр

№24/07

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Эцсийн өмчлөгч өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, 83 дугаар зүйлийн 83.6, 83.7 дахь хэсэг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Крипто Үндэстэн ХК-ийн Эцсийн өмчлөгчөөр бүртгэлтэй байгаа Ганзориг овогтой Мягмаржав (РД:ИЭ95042511)-ийг эцсийн өмчлөгчөөс хассугай.
2. Крипто Үндэстэн ХК-ийн Эцсийн өмчлөгчөөр Гүйцэтгэх захирал Отгонбаяр овогтой Мөнх-Оргил (РД:УК95102210)-ийг бүртгүүлсүгэй.
3. Компанийн эцсийн өмчлөгчийн өөрчлөлтийг Хуулийн этгээд Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, өргөдөл хүсэлт гаргах, холбогдох баримт бичигт гарын үсэг зурах, төлөөлөх зэрэг бүрэн эрхийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Уранцэцэг)-д даалгасугай.

ДАРГА  Ч.ГАНХУЯГ

